| № | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт | Хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | төлөвлөгөө гарган ажиллана. | | | | | нийт 8 үйл ажиллагааны чиглэлээр төлөвлөгөө боловсруулж, 25 хорооны ӨЭМТ-тэй хамтран ажилласан. Аяны хүрээнд нийт эмэгтэйчүүдийн урьдчилсан сэргийлэх үзлэгт хамрагдсан-14502 /24.9%/, үүнээс өвчтэй илэрсэн-580, Эрүүлжилт-95% | |
| 3.1 0 | “Эх барих эмэгтэйчүүд”-ийн тусламж үйлчилгээний чанар сайжруулах аяныг зохион байгуулна | Гүйцэтгэлийн төсөв | Хамрагдсан иргэдийн тоо, арга хэмжээ | Арга хэмжээ 2, хамрагдсан иргэдийн тоо-500 | Арга хэмжээ 4, хамрагдсан иргэдийн тоо-1200 | Нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн тусламж үйлчилгээний чанар хүртээмж сайжруулах сэдэвт 3 сарын аяныг зохион байгуулсан. Тухайн аянд хамрагдсан нөхөн үржихүйн насны 14502 эмэгтэйчүүд байна. | 100 % |
| 3.11 | Бага насны хүүхдийн суурь өвчлөл, хоол тэжээлийн цочмог дутлыг илрүүлэн, бүртгэх цахим хяналтын системийг өрхийн эрүүл мэндийн төвүүдэд нэвтрүүлэх ажлыг үе шаттай хийнэ | Улс, нийслэл, дүүргийн төсөв | Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь | Үйл ажиллагааны хэрэгжилт 80% | Үйл ажиллагааны хэрэгжилт 85% | Гүүд Нэйборс ОУТББ-ын Монгол дахь Төлөөлөгчийн газар болон Хан-Уул дүүргийн 6-р хорооны Чанд-Авиа ӨЭМТ хамтран “Хоол тэжээлийн хөтөлбөрийг” хэрэгжүүлэн зорилтот бүлгийн 4 хүүхдийг хамруулан эмчлэн эрүүлжүүлэх ажлыг 2024 оны 7 дугаар сарын 1 өдрөөс 9 сарын 10 хооронд амжилттай зохион байгууллаа. Хөтөлбөрт хамрагдсан 2-6 насны 4 хүүхдэд хоололтын зөвлөгөө, эмчийн үзлэг, витаминжуулалт, эрүүл мэндийн зөвлөгөө, хоололтын гарын авлагыг эцэг эх асран хамгаалагч нарт сар тутам өгсөн. GEREGE medtech “ Хоол тэжээлийн цочмог дутал илрүүлэг систем”-тэй холбоотой мэдээллээр Эрүүл мэндийн төвийн мэдээлэл технологийн алба, хүүхдийн зохицуулагч эмч хамтран цахим сургалт зохион байгуулж ӨЭМТ бүрэн хамрагдсан. Системийн хэрэгжилт, бүртгэл мэдээлэл 100%-ийн хэрэгжилттэй явагдаж байна. ХТЦД-тай илэрсэн : 6<br>2024 онд 4 хүүхдийг эмчилгээний бэлэн хоолоор ханган хяналтад авч эрүүлжүүлэн ажиллаж байна. | 100 % |

| № | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт | Хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 2024 оны 10 сарын байдлаар 694 хүүхдийг өвчний учир хяналтад авч 463 хүүхдийг эрүүлжүүлсэн, эрүүлжилтийн хувь 67% Үр дүн: Суурь өвчний илрүүлэлт сайжирсан байна. | |
| 3.12 | Хөгжлийн бэрхшээлтэй нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийг урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд хамруулах | Улс, нийслэл, дүүргийн төсөв | Үйлчилгээнд хамрагдсан иргэний тоо | Арга хэмжээ 2, хамрагдсан иргэдийн тоо-150 | Арга хэмжээ 4, хамрагдсан иргэдийн тоо-170 | Нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн тусламж үйлчилгээний чанар хүртээмж сайжруулах сэдэвт 3 сарын аяныг зохион байгуулсан. Тухайн аянд хөгжлийн бэрхшээлтэй нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийг урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд 701 иргэн хамрагдсан байна. | 100 % |
| 3.13 | “Сайн туршлага-2024” шилдэг бүтээл шалгаруулах арга хэмжээг зохион байгуулна. Эмнэлзүйн сайн туршлагыг бүртгэн мэдээлэх, сурталчлах ажлыг өрнүүлнэ. | 550,000 | Аян зохион байгуулж шалгаруулсан байна. | 2023 онд 2 номинацид оролцож 2 шалгарсан | “Сайн туршлага арга” хэмжээнд оролцох номинацийн төрлийг нэмэгдүүлсэн байна | Хан-Уул Эрүүл мэндийн төвийн “Сайн туршлага 2024” арга хэмжээг 2024 оны 10 сарын 15-ны өдөр ЭМТҮЧАБ албанаас зохион байгууллаа. ХУЭМТ-өөс 2 бүтээл , 6 Өрхийн Эрүүл мэндийн төвийн 15 бүтээл оролцсоноос, Нийслэлийн Эрүүл мэндийн газрын “Сайн туршлага 2024” арга хэмжээний 2 дугаар шатны шалгаруулалтанд 14 бүтээлээр оролцсон<br>Сайн туршлага 2024 арга хэмжээний 2-р шатны шалгаруулалтааас ХУД-ийн 2-р хороны Тэрмэстий ӨЭМТ – “Өрхийн эмч нарт зориулсан зайлшгүй шаардлагатай удирдамж зааврuудын эмхэтгэл” I, II товхимол ном -дэд байранд шалгарч, 11 бүтээл батламж авсан байна. | 100 % |

| № | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт | Хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3.14 | Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмж аюулгүй байдлыг сайжруулна. | 5 сая | Зохион байгуулсан аян, өдөрлөгийн тоо | 3 аян зохион байгуулсан. | 3 аян, 3 өдөрлөг | ЭМТҮЧАБ албанаас дараах 3 аяныг зохион байгуулсан.1 ЭМТ-ийн эмч ажилчдын дунд “Ажилтан бүр хөтөч” аяныг 2024 оны 02 сарын 01-ний өдрөөс 06 сарын 01 хүртэл 4 сарын хугацаанд зохион байгууллаа. Аяны хугацаанд 7 багийн гишүүд ажлын төлөвлөгөөг гаргаж, хөтөчийн ажлыг хуваарийн дагуу хийж, ЭМС-н А/352, А/220, А/566, А/814, Монгол Улсын MNS6211: 2019 стандарт, MNS 7014: 2023 стандартыг мөрдөн ажиллаа. Аяны хүрээнд сургалт 7 удаа, АХА тэмцээн 1 удаа, болзолт уралдаан 3 удаа, хөгжөөнт тэмцээн уралдаан 3 удаа зохион байгуулагдсан. Аяны шалгаруулалтанд 3.2 сая төгрөг зарцуулсан. “Нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдэд үзүүлэх тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулъя” аяныг 2024 оны 01 сарын 10-ны өдрөөс 04 сарын 10 хүртэл 3 сарын хугацаанд зоихион байгуулсан.· Аяны хүрээнд нийт 8 үйл ажиллагааны чиглэлээр төлөвлөгөө боловсруулж, 25 хорооны ӨЭМТ-үүдтэй хамтран ажилласан. Аяны хүрээнд эмэгтэйчүүдийн урьдчилсан сэргийлэх үзлэгт хамрагдсан-14502 /24.9%/, үүнээс өвчтэй илэрсэн-580, эрүүлжилт-95% “Хүүхдэд үзүүлэх тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулъя“ аяныг 2024 оны 01 сарын 15-ны өдрөөс 04 сарын 15 хүртэл 3 сарын хугацаанд зохион байгуулсан. Аяны үр дүн: 5 хүртэлх насны хүүхдийн гэрийн эргэлт--90%-д хүрсэн. Өдөрлөг -“Эрүүл Монгол“ өдөрлөг 2024.05.29-ны өдөр зохион байгуулсан. -2024.09.17-нд Үйлчлүүлэгчийн аюулгүй байдлын өдөр -ийг зохион байгуулж өдөрлөгт эмч эмнэлгийн ажилтан,иргэд нийт 200 гаруй хүн оролцлоо. Тухайн өдөрлөгт 8 чигэлээр сургали зохион | 100 % |

| № | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт | Хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | байгуулж 56 эмч ажилтан хамрагдлаа Дэлхийн гар угаах" өдрийг тохиолдуулан халдвар сэргийлэлтийн алба, сувилахуйн алба хамтран амбулаториор үйлчлүүлэгчдийн дунд өдөрлөг зохион байгуулж, гарын эрүүл ахуй сахих, ТТӨ сэргийлэх 6 төрлийн гарын авлага материал 150ш тарааж, гар угаах халдваргүйжүүлэх арга зүйн зөвлөгөө өгч үйлчлүүлэгчдэд маск, гар халдваргүйжүүлэх уусмалаар 50 хүнд үйлчилгээ үзүүллээ | |
| 3.15 | Спирограммын оношилгоо, эмчилгээний үйл ажиллагааг өргөжүүлэх | Гүйцэтгэлийн төсөв | Оношилгоонд хамрагдсан иргэний тоо | Спирограммын оношлогоо 80 иргэн | Спирограммын оношлогоо 98 иргэн | 2024 оны байдлаар 113 иргэнд спирометрийн шинжилгээ хийсэн. Үүнээс хэвтэн эмчлүүлэх тасагт 37 өвчтөнд хийсний 17 иргэн амьсгал бөглөрлийн хөнгөнөөс- хүнд зэргийн хам шинж 5 иргэнд илэрч оношилгоо, эмчилгээний зөвлөмжийг өгч ажиллаа. Амбулаториор үйлчлүүлж буй уушигны эмгэг асуумжтай 99 иргэний шинжилгээг хийж хяналтанд байдаг 45 хүнд амьсгал бөглөрлийн өөрчлөлт илэрсэн. Мөн 10 үйлчлүүлэгч амьсгал бөглөрлийн дунд болон 1-р зэргийн өөрчлөлт илэрсэн байна.FEV1- амьсгал гаралтын сек/дэх хүчлэн гаргах амьсгалын эзлэхүүн 69%-60%-7 иргэн, 59%-50%- 2 иргэн, 35%-49%-1 иргэ. FVC-уушигний хүчилсэн амьдралын багтаамж 27 иргэнд хийсэн. Дээрх иргэдэд эмчилгээ зөвлөгөө өгч ажилласан. | 100 % |

| № | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт | Хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3.16 | Уламжлалт, Сэргээн засах өдрийн эмчилгээний үйл ажиллагааг өргөжүүлэх | Гүйцэтгэлийн төсөв | Өдрийн уламжлалт, сэргээн засах эмчилгээг нээнэ | 2023 онд өдрийн эмчилгээ 85 иргэн үйлчлүүлсэн | Өдрийн эмчилгээнд 100 иргэнд | Уламжлалт, сэргээн засах тусламж үйлчилгээний кабинет нь үйл ажиллагаагаа өргөжүүлж ард иргэдэд УАУ-ны болон сэргээн засах эмчилгээг чанартай хүртээмжтэй үзүүлэхээр өдрийн эмчилгээг нээн ажиллуулж байна. УАУ-ны өдрийн эмчилгээнд-232, СЗ өдрийн эмчилгээнд-87 үйлчлүүлэгч хамрагдсан бөгөөд эмчилгээ үйлчилгээгээ шинэ аппарат тоног төхөөрөмжөөр өргөтгөн ажиллаж байна. | 100 % |
| 3.17 | Зүрхний ачаалалтай бичлэг, 24 цагийн зүрхний бичлэг буюу холтер үйл ажиллагааг өргөжүүлэх | Гүйцэтгэлийн төсөв | Холтер хийлгэсэн иргэний тоо | Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг 110 иргэнд хүргэсэн | Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг 250 иргэнд хүргэнэ | 2024 оны байдлаар зүрхний ачаалалтай бичлэг, 24 цагийн зүрхний бичлэг буюу холтерын эмчилгээнд 690 иргэн хамрагдаж тусламж үйлчилгээ авсан. | 100 % |
| 3.18 | Төрийн өмчийн сургууль, цэцэрлэгийн хүүхдүүдэд амны хөндийн гажиг заслын үзлэг, оношилгоо хийж үр дүнг тооцож, Эрүүл мэндийн боловсрол олгоно | Гүйцэтгэлийн төсөв | Үзлэгт хамрагдсан хүүхдийн тоо хувь. Зохион байгуулсан сургалтын тоо | 2500 хүүхдэд 3удаа үзлэг, 3 удаагийн сургалт | 2530 хүүхдэд 4 удаа үзлэг, 4 удаагийн сургалт | Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 322 дугаар тогтоолоор батлагдсан “Эрүүл шүд” арга хэмжээний хүрээнд “Шүд” хөтөлбөрийг хэрэгжүүлэн ажиллаж байна. Хан-Уул дүүргийн Дүүргийн Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт тусгагдсан “Эрүүл хүүхэд-Эрүүл шүд” хөтөлбөрийг эрчимжүүлэх ажлын хүрээнд амны хөндийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг өргөжүүлэх ялангуяа алслагдсан дүүрэг, хороодод амны хөндийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг өргөжүүлэн амны хөндийн үзлэг оношилгоог хийх зорилгоор Дүүргийн Ерөнхий боловсролын 52, 75, 118-р дунд сургуулийн 1-12 ангийн 4568 хүүхдүүд буюу 72 хувийг, Сургуулийн өмнөх боловсрол олгох 65,72,35,325 дугээр цэцэрлэгийн 1292 хүүхэд буюу 81.3 хувийг амны хөндийн эрүүл ахуйн боловсрол олгох сургалт болон амны хөндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулан, шүдний | 100 % |

| № | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт | Хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | цоорол, фторт түрхлэг зэрэг эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлэн эрүүлжүүлэх ажлыг зохион байгуулсан. Дүүргийн 65, 72, 35, 325-р цэцэрлэгийн 25 багшийн амны хөндийг бүрэн эрүүлжүүлэн, сургалтыг хийж, амны хөндийн эрүүл мэндийн сургагч багшаар бэлтгэсэн байна.Мөн 6 настангуулын урьдчилсан сэргийлэх үзлэгийг 35 сургуулийн зүрхний үзлэгээр 5088 хүүхэд,шүдний үзлэгээр 5108 хүүхэд үзлэг оношилгоо хийсэн байна. | |
| 3.19 | Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/396 дугаар тушаалаар батлагдсан Мэдээллийн аюулгүй байдлын журмыг хэрэгжүүлнэ. | Төсөв шаардахгүй | Мэдээллийн аюулгүй байдлын журамтай байна | Эрүүл мэндийн төвийн даргын 2019 оны мэдээллийн аюулгүй байдлын журам | Мэдээллийн аюулгүй байдлын журмын дугуу боловсруулсан байна. | Эрүүл мэндийн төвийн даргын 2023 оны 10 сарын 26-ны өдрийн А/73 дугаар тушаалаар кибер халдлага зөрчлийн үед дагаж мөрдөх төлөвлөгөөг гарган тус тус хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Монгол Улсын засгийн газрын 2023 оны 224 дүгээр тогтоолоор кибер аюулгүй байдлыг хангах нийтлэг журам, 2024 оны 100 дугаар тогтоолоор Эрүүл мэндийн мэдээллийг цуглуулах, боловсруулах, ашиглах, хадгалах, аюулгүй байдлыг хангах журмууд батлагдсан. Эрүүл мэндийн яамны 2018 оны 09 дугаар сарын 17 өдрийн 3-1/3726 тоот тушаалын хэрэгжилтийн хүрээнд Сервер компьютеруудын gateway, DNS хаягуудаар хязгаарлалт хийн интернет орчноос тусгаарласан байдаг. Эмнэлгийн нэгдсэн систем eHealth программ хангамжид хандаж буй хэрэглэгч 76 эмч тоон гарын үсгээр хандалт хийдэг. Эрүүл мэндийн сайдын 2023 оны Эрүүл мэндийн цахим мэдээллийн аюулгүй байдлыг хангаж ажиллах тухай 03 дугаарын албан даалгавар, Нийслэлийн эрүүл мэндийн газрын даргын чиглэл хүргүүлэх тухай 532 албан бичгийн хүрээнд сүлжээний аюулгүй байдлыг хангах FortiGate-100F галт хана авсан.FortiGate-100F төхөөрөмжийг | 100 % |

| № | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт | Хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | шалгуулахаар Тагнуулын Ерөнхий газарт хүсэлт гаргаад байна.Дижитал өвчний түүхийн архив дата серверийн backup долоо хоног бүр хийж 145gb мэдээллийг нөөц серверт хадгалдаг. | |
| 3.2 | Хөнгөвчлөх сувилахуйн тусламж үйлчилгээний чиглэлээр үзүүлэх сургууль зохион байгуулах | Гүйцэтгэлийн төсөв | Хөнгөвчлөх сувилахуйн тусламжийн талаар мэдлэгийг олгосон байна | Сургалтын тоо-1, хамрагдсан албан хаагчдын тоо-30 | Сургалтын тоо-1, хамрагдсан албан хаагчдын тоо-35 | 2024 оны 5 сарын 4 ны өдөр 24 өрхийн эрүүл мэндийн төвийн 38 сувилагчид “Хөнгөвчлөх сувилахуйн тусламж сэдвээр сургалт явууллаа. Сургалтаар ЭМС-н А/41 тоот тушаалыг хэрэгжүүлэх арга зам, сувилгааны түүх хөтлөлтийг жишиг загвараар танилцуулсан байна. 2023 онд бусад 5 дүүрэгт хийгдсэн Хөнгөвчлөх тусламж үйлчилгээ сэдэвт сургалт нь өрхийн сувилагч нарт хүрсэн, ажилдаа манай туршлагыг хэрэгжүүлэн ажиллаж байгаа нь талархууштай. | 100 % |
| 3.21 | Хараа болон харилцааны бэрхшээлтэй эмчлүүлэгчийг таних аргыг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх | Гүйцэтгэлийн төсөв | Өвчтөнийг таних аргыг нэвтрүүлсэн байна. | Өвчтөнийг таних аргыг 15 иргэнд | Өвчтөнийг таних аргыг 20 иргэн | 2024 оны жилийн эцсийн байдлаар хараа болон харилцааны бэрхшээлтэй 45 үйлчлүүлэгчийг танин тодруулж тусламж үйлчилгээ үзүүлсэн байна. Хэвтэн эмчлүүлэх тасагт үйлчлүүлэгчийг зөв танин тодруулах тэмдэг, тэмдэглэгээг хийж орны хөлд туслах сувилагч хариуцан арга зүйчийн зааврын дагуу байршуулан өглөө ээлж хүлээлцэхэд эмчлүүлэгчийн мэдээлэлийг таних тэмдгийн дагуу үнэлгээ хийж хүлээлцэж байна.Түгээмэл хэрэглэгдэж байгаа тэмдэглэгээ нь чихрийн шижинтэй эмчлүүлэгч болон өвдөлттэй эмчлүүлэгчид байна. | 100 % |
| 3.22 | Эмнэл-зүйн болон эм-зүйн тусламж үйлчилгээг өргөжүүлэх | Гүйцэтгэлийн төсөв | Антитодын үүсгэсэн байна | Хэрэгжилтийн хувь | Үйл ажиллагааны хэрэгжилт | Эм зүйн тусламж үйлчилгээний нэг чухал хэсэг нь эмийн хурц хордлого байдаг бөгөөд хими тарианы найрлага, эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэхэд эсэд хортой эмээр хордох эрсдэл өндөр учраас бүх химийн эмчилгээнд оролцдог эмч, сувилагч нарт сургалт зохион байгуулсан. Мөн антидотыг ярилцаж 2025 оноос бүх эм тариаг нь эрчимт | 90% |

| № | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт | Хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | эмчилгээний тасагт тусгай хаяг шошготой байршуулахаар шийдвэрлэсэн. | |
| 3.23 | Эмийн үйлчилгээ, хэрэглэх гаж нөлөө, ижил төстэй эмийн хаягжилт, тун, хадгалалт харилцан үйлчлэлийн мэдээллийн буланг байгуулах | Гүйцэтгэлийн төсөв | Иргэдийг мэдээллээр хангасан байна | Хэрэгжилтийн хувь | Үйл ажиллагааны хэрэгжилт | Эрүүл мэндийн төвийн үйлчүүлэгч ихтэй 3-р давхарыг сонгож эмийн үйлчилгээ , хэрэглэх заалт зэрэг мэдээллүүдийг тусгасан буланг 100% тохижуулсан. Эмийн гаж нөлөөг бүртгэн мэдээллэх QR кодыг эмнэлгийн давхар болгонд байршуулсан бөгөөд энэ QR кодоор иргэд өөрсдөө болон эмч, сувилагч, эмнэлгийн мэргэжилтэнгүүд эмийн гаж нөлөөг шууд бүртгэн мэдээлэх сургалт сурталчилгааг тогтмол хийж нийт 45 орчим эмч эмнэлгийн мэргэжилтэн хамрагдсан. Эмийн зохистой хэрэглээ болон эмийн гаж нөлөөний сургалт сурталчилгааг өдөрлөг хэлбэрээр иргэд үйлчлүүлэгч нарт 2024/09/23, 2024/11/23 өдөр тус тус танилцуулж мэдээлэл түгээсэн. Нийт 2500 хүн хамрагдсан. Эрүүл мэндийн PAGE хуудсаар 9000 хүний хандалт авсан. | 100 % |
| Зорилго 4: Хуулиар тусгайлан олгосон чиг үүрэг, байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах зорилгын хүрээнд | | | | | | | |
| Зорилт 4.1: Төсвийн сахилга батыг сайжруулах үр ашигтай байдлыг нэмэгдүүлэх, байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах ажлын хүрээнд | | | | | | | |
| 4.1 | Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж байгууллагын төсвийн мэдээллийг тогтмол байршуулах | Төсөв шаардахгүй | Шилэн дансны мэдээллийг хуулийн хугацаанд байршуулсан байна. | 2023 онд хууль, журмын хүрээнд 142 удаа шилэн дансны мэдээллийг | Хуулийн хүрээнд тухай бүр мэдээллийг байршуулсан байна | 2024 оны 10 дугаар сарын байдлаар шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор 84 тоон мэдээллийг байршуулан ажилласан байна. Үүнд: багууллагын батлагдсан төсөв, байгууллагын батлагдсан орон тоонд гарсан өөрчлөлт, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого зарлагын мөнгөн гүйлгээний дүнгийн тоон мэдээллийг байршуулсан байна. | 100 % |

| № | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт | Хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | байршуулсан | | | |
| 4.2 | Төсвийн орлогын төлөвлөгөөг биелүүлж, гүйцэтгэлийг тайлагнаж ажиллах | Төсөв шаардахгүй | Гүйцэтгэлийн дүн, хувь | 2023 оны төлөвлөгөөний гүйцэтгэл 100% | 2024 оны төлөвлөгөөний гүйцэтгэл 100% байна. | Хан-Уул эрүүл мэндийн төв нь 2024 оны 10 дугаар сарын байдлаар 8,4 тэрбум төгрөг төвлөрүүлэх төлөвлөгөөтэй ажиллсанаас 10,3 тэрбум төгрөгийн орлогыг төвлөрүүлэн төлөвлөгөөг 22 хувиар давуулан биелүүлж ажиллаж байна. | 100 % |
| 4.3 | Төсвийн батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж хяналт тавих, үр дүнг дээшлүүлэх, гүйцэтгэлийг тайлагнаж ажиллах | Төсөв шаардахгүй | Материалаг зөрчилгүй ажилласан эсэх | Материалаг зөрчилгүй ажилласан байна. | Төсвийг зориулалтын дагуу зарцуулж, зөрчилгүй ажилласан байна | Төсвийн батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж хяналт тавих, үр дүнг дээшлүүлэх, гүйцэтгэлийг тайлагнах ажлын хүрээнд батлагдсан төсвийг төсвийн хуваарийн дагуу сар бүр зарцуулж гүйцэтгэлийн мэдээг сар бүрийн 1-ний өдөр Нийслэлийн Эрүүл мэндийн газарт хүргүүлэн баталгаажуулан ажиллаж байна. | 100 % |
| 4.4 | Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжилтийг хангаж ажиллах | Төсөв шаардахгүй | Хэмнэгдсэн зардлын хувь, хэрэгжилт | Хуулийн хэрэгжилтийг хангаж ажилласан байна | Хуулийн хэрэгжилтийг хангасан байна | Төрийн хэмнэлтийн тухай хулийн хэрэгжилтийг хангаж 2023 оны мөн үетэй харьцуулахад нийт зардлыг 12,4 хувиар бууруулан ажилласан байна. | 100 % |
| 4.5 | Эрүүл мэндийн төвийн цахилгааны тэжээлийг солих, нөөц эх үүсвэр хүчин чадлыг нэмэгдүүлэх | Байгууллагын төсөв | Хэрэгжилтийн биелэлт | Цахилгааны хэвийн үйл ажиллагааг хангасан | Цахилгааны найдвартай үйл ажиллагааг хангагдсан байна. | Төвийн цахилгааны тэжээлийг солих, нөөц эх үүсвэр хүчин чадлыг нэмэгдүүлэх, аюулгүй байдал, Эрүүл мэндийн тусламж үйлчилгээг тасралтгүй хангах ажлын хүрээнд цахилгааны тэжээлийг солих, нөөц эх үүсвэр хүчин чадлыг нэмэгдүүлэх | 60% |

| № | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт | Хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | талаар тооцоллыг гарган үе шаттайгаар зохион байгуулан ажиллахаар төлөвлөөд байна. | |
| 4.6 | Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг иргэдэд ая тухтай, таатай орчин нөхцөлд хүргэх ажлын хүрээнд байгууллагын сантехникийн болон өрөөний урсгал засварыг төлөвлөгөөний дагуу зохион байгуулах | Байгууллагын төсөв | Засвар үйлчилгээг хийсэн өрөөний тоо, шугам хоолой хэмжээ | Байгууллагын урсгал засварын хуваарийн дагуу зохион байгуулна | Иргэд таатай орчинд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг авсан байна | Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг иргэдэд ая тухтай, таатай орчин нөхцөлд хүргэх ажлын хүрээнд хүлээн авах яаралтай тусламж, эрчимт эмчилгээний тасагт хэвтэж байгаа өвчтний сахиж байгаа иргэдийг амрах өрөөг тохижуулсан, мөн өргөтгөлт байрлах хүлээн авах тасгийн гаднаас орох орц, гарцны гадна талд шилэн гонхыг шинээр хийсэн. Хэвтэн эмчлүүлэх тасагт үйлчлүүлэ байгаа иргэдийн ая тухтай нөхцлийг бүрдүүлэх зорилгоор 00 орох хэсгийг тэргэнцэртэй иргэдэд саадгүй үйлчлүүлэхээр болгон налуу болгон суултуур, бариул, түшүүргийг байрлуулж бусдын тусламжгүйгээр үйлчлүүлэх боломжийг хангаж ажилласан. 2025 оны орон нутгийн төсөвт сантехникийн засвар үйлчилгээг хийлгэхэд нэн шаардлагатай байгаа 180 сая төгрөгийн засвар үйлчилгээний саналаа хүргүүлэн ажиллаж байна. | 92% |
| 4.7 | Ажлын байрны аюулгүй байдлыг хангах ажлын хүрээнд хүчилтөрөгчийн шугам хоолой татах, нэгдсэн системтэй болгох | Байгууллагын төсөв | Засвар үйлчилгээг хийсэн өрөөний тоо, шугам хоолой хэмжээ | Байгууллагын урсгал засварын хуваарийн дагуу зохион байгуулна | Иргэд таатай орчинд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг авсан байна | Эрүүл мэндийн төвөөр үйлчлүүлж байгаа иргэдийн аюулгүй байдал, эмч бусад албан хаагчдын ажлын байрны аюулгүй байдлыг хангах ажлын хүрээнд хүчилтөрөгчийн шугам хоолойг нэмэлтээр эрчимт эмчилгээний тасагт 70м шугам хоолой 6 гаралттайг угсарч хэвийн ажиллагааг хангаж ажиллаж байна | 100 % |

| № | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт | Хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 4.8 | “Тэрбум мод” үндэсний хөтөлбөрийн хүрээнд мод тарих арга хэмжээнд оролцон, мод тарих | Байгууллагын төсөв | Тарьсан модны тоо | “Бүх нийтээр мод тарих үндэсний өдөр” арга хэмжээнд 2023 онд 10 сард оролцож 45ш мод тарьсан байна. | “Тэрбум мод” үндэсний хөтөлбөрийн арга хэмжээнд оролцох 45-аас доошгүй мод тарьсан байна. | Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд 2024 оны 05 дугаар сард Эрүүл мэндийн Төвийн хамт олны төлөөлөл “Denk Farm”-тай хамтран 25 ширхэг мод тарьж, усалгааг хийлээ. Мөн эрүүл мэндийн төвийн гадна фасад, гадна тохижилтын ажлын хүрээнд шинээр байгуулсан ногоон байгууламжинд 30 ширхэг мод бут тарьж, арчилгааг хийж ажиллаж байна. | 100 % |
| 4.9 | Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газрын ирсэн захирамж, тушаалын дагуу бүх нийтийн их цэвэрлэгээнд хуваарийн дагуу оролцож, биелэлт, хэрэгжилт тайланг илгээх | Төсөв шаардахгүй | Цэвэрлэгээнд оролцсон тоо, албан хаагчдын тоо | 2023 онд 10 удаагийн бүх нийтийн цэвэрлэгээ 304 албан хаагчийг хамруулсан | 2024 онд 11 нийтийн цэвэрлэгээ, 310 албан хаагчийг хамруулах | 2024 оны 02 дугаар сарын 03, 08 өдрүүд, 03 дугаар сарын 04, 04 дүгээр сарын 02, 07, өдрүүдэд бүх нийтийн их цэвэрлэгээнд оролцож, орчны 50 метр талбайн хог хаягдал, цас мөсийг цэвэрлэсэн. Цэвэрлэгээнд нийт 204 эмч ажилчид оролцож, 2,5 тонн хог хаягдал, 150 мкв талбайн цас мөс, хог хаягдлыг цэвэрлэж ачуулсан. Мөн байгууллагын гадна орчны хайс, хашлага, шат довжоо,сандал, хогийн сав, гадна хаягийг 2 удаа угааж, хүлээлгийн 4 сандал, 2 хогийн савыг будсан. | 95% |
| 4.1 | Эрүүл мэндийн төвийн орчны аюулгүй байдал, гадна талбай тохижилтыг нэмэгдүүлэх | Улс, нийслэл, дүүргийн төсөв | Төвийн гадна ногоон байгууламжийг нэмэгдүүлсэн байна | Дүүргийн хөрөнгө оруулалтаар төвийн гадна талбай, тохижилтийг ажлыг хийсэн | Төвийн гадна ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, тарьсан модны арчилгааг тогтмол хийж | Эрүүл мэндийн төвийн орчны аюулгүй байдал, гадна талбай тохижилтыг нэмэгдүүлэх ажлын хүрээнд Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар засвар үйлчилгээг хийсэн гадна талбайн тохижилтын арчилгаа, үйлчилгээг тогтмол хийж ажиллаж байна. | 100 % |

| № | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт | Хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | ажилласан байна. | | |
| Зорилго 5: Төрийн албан хаагчийн сахилга хариуцлагын нэмэгдүүлэх жендэрийн эрх тэгш байдлыг хангах зорилгын хүрээнд | | | | | | | |
| ЗОРИЛТ 5.1 ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН ЁС ЗҮЙН, ХЭМ ХЭМЖЭЭГ МӨРДӨЖ АЖИЛЛАХ СОЁН ГЭГЭЭРҮҮЛЭХ, НӨЛӨӨЛӨЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЗОХИОН БАЙГУУЛАХ | | | | | | | |
| 5.1 | Төрийн албан хаагчийн Ёс зүйн хэм хэмжээг мөрдөж ажиллах, соён гэгээрүүлэх сургалтыг зохион байгуулж, нөлөөллийн ажлыг зохион байгуулах | 2 сая | Ёс зүйн хэмжээг чанд мөрдөн ажиллах, зөрчлийн тоо хэмжээ буурсан байна. | 2023 онд албан хаагчдад чиглэсэн сургалтыг 2 удаа, нөлөөллийн ажлыг 1 удаа зохион байгуулсан. | Албан хаагчдад чиглэсэн сургалтыг 2 удаа, нөлөөллийн ажлыг 1 удаа зохион байгуулсан. | 2024 оны 03 дугаар сарын 05-ний өдөр Эрүүл мэндийн салбарын албан хаагчдийг хууль эрх-зүйн мэдлэгийг дээшлүүлэх сургалтыг зохион байгуулсан. Төрийн албан хаагч ажлын байрандаа албан үүргээ гүйцэтгэхэд хуулийн мэдлэг олгох, аливаа хууль бус үйл ажиллагаанд татагдан орох, авилга, албан тушаалаа урвуулан ашиглахаас урьдчилан сэргийлж, зөв зохистой хандлага, харилцааг бий болгоход сургалтын зорилгоор нийт тасаг, нэгжийн эмч, эмнэлгийн мэргэжилтэн, бусад албан хаагчид 88 хамрагдсан байна. Эрүүл мэндийн төвөөр үйлчлүүлж байгаа иргэдийг зөрчлийн тухай хуулиар танин мэдүүлэх нөлөөллийн ажлыг зохион байгуулсан | 95% |
| 5.2 | Эрүүл мэндийн төвийн дэргэдэх Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагааны тайлан болон загварын тайлан, мэдээг хагас, бүтэн жилээр хүргүүлэх, биелэлтийг хариуцан ажиллах | Төсөв шаардахгүй | Тайлан мэдээг хүргүүлсэн байна. | Төлөвлөгөө-1 Тайлан-2, бусад мэдээлэл-1 удаа хүргүүлсэн байна. | Төлөвлөгөө-1 Тайлан-2, бусад мэдээллийг тухай бүр хүргүүлэн ажиллана | Эмнэлгийн дэргэдэх Ёс зүйн хэсгийн хороо нь 2024 төлөвлөгөөг 2 зорилго, 8 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөн ажиллаж байна. Төлөвлөгөөний хэрэгжилт 95%, Нийслэл, дүүргийн дээд шатны байгууллагад үйл ажиллагааны тайлан болон загварын тайлан, мэдээг тухай бүр хүргүүлэн ажилласан. | 98% |
| 5.3 | Төрийн албаны сахилга, хариуцлага, дэг журмыг чангатгах тухай 258 дугаар тогтоолын | 2 сая | Тогтоолын хэрэгжилтийг ханган ажилласан байна. | Төрийн албаны сахилга, хариуцлага, дэг журмыг | Төрийн албаны сахилга, хариуцлага, дэг журмыг сайжруулах | 1.2024 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн бүх ажилчдын мэдээллийг ERP программд бүрэн оруулж, цаг бүртгэлийн системтэй холбож, цаг ашиглалтанд хяналт тавин ажиллаж байна. Мөн шинээр ажилд орсон эмч, ажилчдад цаг ашиглалтын журмыг танилцуулсан. | 100 % |

| № | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт | Хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хэрэгжилтийг хანган ажиллах | | | сайжруулах арга хэмжээг-2 | арга хэмжээг-2 | 2.2024 оны эхний хагас жилийн байдлаар:<br>● Хавдрын хими эмчилгээний эмч-1<br>● Хараазүйн мэргэшүүлэх сургалтад-1<br>● Ургийн хэт авиа оношилгооны сургалтад-1<br>● Хятад ард улсын Хөх хотод "Уламжлалт анагаах ухааны эмч нарыг чадавхжуулах 14 хоногийн сургалт"-1 эмч тус тус хамрагдлаа.<br>3.Жирэмсний амралттай байгаа-2<br>4.Нийслэлийн Засаг даргын 2022 оны 08 сарын 15-ны өдрийн "Журам шинэчлэн батлах тухай" А/1049 дүгээр захирамж, Нийслэлийн эрүүл мэндийн газрын даргын 2022 оны 06 сарын 06-ны өдрийн "Журам батлах тухай" А/105 дугаар тушаалын дагуу Хан-Уул эрүүл мэндийн төв нь өргөдөл, гомдлын тайланг улирал бүр гарган хугацаанд нь хүргүүлэн, хэрэгжилтийг хანган ажиллаж байна. 2024 оны эхний 11 сарын байдлаар нийт ирсэн өргөдөл, гомдол-482. Үүнээс:<br>Өрхийн Эрүүл мэндийн төвтэй холбоотой – 225 буюу 46,68%<br>2.Эрүүл мэндийн төвтэй холбоотой 254 буюу 52.69%<br>3.Эрт илрүүлэгтэй холбоотой 3 буюу 0,62%, Шийдвэрлэлтийн дундаж хугацаа 4 хоног 0 цагтай. Хугацаа хэтэрч шийдвэрлэсэн өргөдөл байхгүй. Шийдвэрлэлтийн дундаж хувь 98%-тай байна. 2024 оны эхний хагас жилийн байдлаар гомдол, санал, хүсэлт, талархалыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад талархалын тоо 1 дахин өссөн, гомдлын тоо 5%-иар буурсан үзүүлэлттэй. өргөдлийн хаалтыг хууль эрх зүйн үндэслэлтэй хааж иргэн болон хуулийн этгээдээс өргөдөл гомдол гаргахгүй байх талаар анхаарч ажиллаж байна. | |

| № | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт | Хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 5.4 | Байгууллагын алба хаагчдын жендэрийн чиглэлээр статистикийн мэдээллийн нэгдсэн сантай болох, хүйсээр ангилсан тоон тайлангийн хэрэглээг нэвтрүүлэх | Төсөв шаардахгүй | Мэдээлэлийн сантай болсон байна | Алба хаагчдын нэгдсэн судалгаатай болович хүйсийн харьцааны харьцуулсан судалгаа байхгүй | Сүүлийн 3 жилийн хүйсийн харьцааны нарийвчилсан судалгааг гаргасан байна. Мэдээлэлийн сантай болсон байна | Эрүүл мэндийн төвийн нийт эмч, эмнэлгийн мэргэжилтний нэгдсэн судалгааг жил бүр гарган, хүйсээр ангилсан тоон мэдээ, судалгааны нэгдсэн сан үүсгэн ажиллаж байна.<br>Тус эрүүл мэндийн төв нь 2022 онд нийт 224 эмч, эмнэлгийн ажилтнаас эрэгтэй 21, нийт ажилчдын 9.3%, 2023 онд нийт 208 эмч, эмнэлгийн мэргэжилтнээс эрэгтэй-24, нийт ажилчдын 11.5%, 2024 онд нийт 214 эмч, эмнэлгийн мэргэжилтнээс эрэгтэй-27 нийт ажилчдын 12.6%-ийг эзэлж байна.<br>Нэгдсэн эмнэлгийн бүтэц MNS 5095-2017 стандартад нийцүүлэн эмч, эмнэлгийн ажилчдын зохистой харьцаанд 80:20 харьцаанд хүргэхээр зорилт тавин ажиллаж байна. | 100 % |
| 5.5 | Эмч, ажилчдыг авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх ажлыг үе шаттай зохион байгуулж, байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлыг хангаж ажиллана /ҮХ2.1/ | Аж ахуй нэгж байгууллага, Төслийн санхүүжилт | Зохион байгуулсан сургалт,хамрагдсан албан хаагчийн тоо | 2 удаагийн сургалтад 11 албан хаагч хамруулсан | 3 удаагийн сургалтад давхардсан тоогоор 115 албан хаагч хамруулна | "Авлигатай тэмцэх жил"-ийн аяны мэдээ мэдээллийг вэб хуудсанд, албан хаагч нарт танилцуулан мэдээллийн ил тод байдлыг хангаан ажиллаж байна. 2024 оны 04 дугаар сарын 12-ны өдөр Эрүүл мэндийн төвийн эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдэд бүх ажилчдын хурлаар “МЭДЬЕ, НЭГДЭЕ” аяны хүрээнд “Шударга бус зүйлд үгүй гэж хэлье” сэдэвт сургалтыг эмч, сувилагч нарт 2 удаагын сургалтаар нийт 174 ажилтан хамрагдлаа.<br>Авлигын эсрэг хууль тогтоомж болон төрийн албан хаагчийн мөрдөх зүйлийг Эмнэлгийн мэргэжилтний Ёс зүйн болон ил тод байдлын самбарт байршуулж хэвшсэн.<br>АТГ-аас бэлтгэсэн шторк, инфографик, нийтлэл, зурагт хуудас, цахим ном, гарын авлага зэргийг байгууллагын дотоод групп, албан ёсны цахим хуудас болон нийгмийн сүлжээ (фэйсбүүк, твиттер), мөн лед дэлгэц, сурталчилгааны самбарт байршуулах зэрэг бүхий л боломжтой хэлбэрээр | 95% |

| № | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт | Хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | олон нийтэд хүргэсэн, Эмч нарын өрөөний хаалганд Авлига ашиг сонирхолоос ангид байх хуулийн заалтууд байршуулсан. Эрүүл мэндийн төвд 2024 онд шинээр ажилд орсон 59 албан хаагчдад авлигын эрсдэлээс хэрхэн урьдчилан сэргийлэх талаарх мэдлэг олгох сургалтыг зохион байгуулсан. | |

ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЯНАСАН: ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ
НИЙСЛЭЛИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН
ГАЗРЫН ДАРГА П.ЭРХЭМБУЛГАН

(тэмдэг) ……………….
(огноо)

ТӨЛӨВЛӨГӨӨГ ТАЙЛАГНАСАН: ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ
ХАН-УУЛ ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН ДАРГЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Н.НАРАНБААТАР

тэмдэг) ……………….
(огноо)

| Д/Д | СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОН ҮНДЭСЛЭЖ БАЙГАА БУСАД БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ, ХУУЛЬ ТОГТООМЖ | ТӨСӨВ | ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ | СУУРЬ ТҮВШИН | ЗОРИЛТОТ ТҮВШИН | ХҮРСЭН ТҮВШИН БУЮУ ХЭРЭГЖИЛТ | Хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | албан ёсны цахим хуудас болон нийгмийн сүлжээ (фэйсбүүк, твиттер), мөн лед дэлгэц, сурталчилгааны самбарт байршуулах зэрэг бүхий л боломжтой хэлбэрээр олон нийтэд хүргэсэн, Эмч нарын өрөөний хаалганд Авлига ашиг сонирхолоос ангид байх хуулийн заалтууд байршуулсан. Эрүүл мэндийн төвд 2024 онд шинээр ажилд орсон 59 албан хаагчдад авлигын эрсдэлээс хэрхэн урьдчилан сэргийлэх талаарх мэдлэг олгох сургалтыг зохион байгуулсан. | |

ТАНИЛЦСАН:
ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ
ЗАСАГ ДАРГА Б.ЦЭРЭН

........................
(Огноо)

ТАЙЛАГНАСАН:
ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ,
ХАН-УУЛ ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Н.НАРАНБААТАР

........................
(Огноо)